

# “ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК

2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр

№ ХЭХ 04/2020

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

Компанийн 2019 оны үйл ажиллагааны  
болон санхүүгийн тайлан баталж, компанийн  
энгийн хувьцааг хуваах тухай

Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дах хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.6, 62.1.9, 62.1.15 дэх хэсгүүд, 63 дугаар зүйл, 69 дүгээр зүйл, “Хар хорум пропертийс” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.1, 8.6.4, 8.6.5, 8.6.8, 8.6.9 дах заалтууд, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн ТУЗТ 05/2020 тоот тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. Компанийн 2019 оны жилийн үйл ажиллагааны тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн эцсийн байдлаар аудит хийгдсэн жилийн эцсийн санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
3. Компанийн нэг бүр нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 15'787'457 (арван таван сая долоон зуун наян долоон мянга дөрвөн зуун тавин долоо) ширхэг энгийн хувьцааг 10 (арав) хувааж нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 157'874'570 (нэг зуун тавин долоон сая найман зуун далан дөрвөн мянга таван зуун дал) ширхэг энгийн хувьцаа болгон хуваасугай.
4. Компанийн дүрмийн 3.1-т буй эрхлэх үндсэн үйл ажиллагааны чиглэлээс “3.1.1 гадаад худалдаа; 3.1.2. үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх; 3.1.3 үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах; 3.1.4 үл хөдлөх хөрөнгө худалдан авах, худалдахад зуучлах; 3.1.5 үл хөдлөх хөрөнгө түрээслэх; 3.1.6 үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар тодорхойлсон үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх;” хэсгийг хасаж, дүрмийн 9.10.6-д “хараат болон охин компани ” гэж нэмж оруулсугай.
5. Компанийн энгийн хувьцаа хуваасантай холбогдуулан дүрмийн 5.1, 5.4 дэх хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

а/ “ 5.1. Компани нь нэг бүрийн 10 \арав\ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 20'000'000'000 \хорин тэрбум\ ширхэг зарласан энгийн хувьцаатай байх бөгөөд зарласан хувьцаа нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд хамаарахгүй.”

б/ “ 5.4.Компани нь нэг бүрийн 10 \арав\ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 19,842,125,430 \арван есөн тэрбум найман зуун дөчин хоёр сая нэг зуун хорин таван мянга дөрвөн зуун гуч\ ширхэг зарласан энгийн хувьцааг хууль болон энэхүү дүрэмд заасан журмын дагуу гүйлгээнд гаргах эрхтэй байна. Зарласан энгийн хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэх эрхтэй байна.”

6. Энэ шийдвэрийн 3, 4, 5 дах хэсэгт шийдвэрлэсний дагуу Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
7. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн №ТУЗТ 03/2020 тоот тогтоолоор охин компани үүсгэн байгуулах, компанийн энгийн хувьцаа худалдан авахаар шийдвэрлэсний дагуу компанийн бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг дахин хийлгэж, зарласан хувьцаанаас эргэлтэд гаргаж санхүүжүүлэх эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.
8. Энэхүү шийдвэр батлагдсантай холбогдуулан компанийн хувьцааны нэрлэсэн үнэ, тоо өөрчлөгдөж дүрэмд нэмэлт, өөрчлөлт орсныг эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, холбогдох зөвшөөрөл авах ажлыг зохин байгуулахыг Гүйцэтгэх захирал /Ц. Хүдэрмөнх/-д даалгасугай. Бүртгүүлэхтэй холбоотой ажиллагаанд компанийг төлөөлөх, гарын үсэг зурах, компанийн тэмдэг (тамга) ашиглах эрхийг Гүйцэтгэх захирал /Ц. Хүдэрмөнх/-д үүгээр олгосугай.

